



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/90

Хэрлэн сум

“Чингис фестиваль-2019” олон улсын
ардын урлагийн наадмыг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын “а”, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.2.1 заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх” дэд хөтөлбөр батлах тухай 15 дугаар тогтоол, “Чингис хаан брэнд” дэд хөтөлбөр батлах тухай 17 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх” болон “Чингис хаан брэнд” дэд хөтөлбөрийн хүрээнд Чингис хотод зохион байгуулагдах “Чингис фестиваль - 2019” олон улсын ардын урлагийн гуравдугаар наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:	Г.Хэрлэнчулуун	-Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Г.Лхагвахатан	-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд:	Э.Мөнх-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Л.Бат-Октябрь	-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	С.Оюун-Эрдэнэ	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Цогт-Эрдэнэ	-Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын даргын үүргийг хавсран гүйцэтгэгч
	Ц.Идэрбат	-Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч
	Б.Дархантөр	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	С.Мөнхцэцэг	-Боловсрол, соёл урлагийн газрын дарга

2//.

Г.Нэргүйбаатар	-Биеийн тамир спортын газрын дарга
Б.Энх-Эрдэнэ	-Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга
О.Гомбобаатар	-“Өндөрхаан хот тохижилт” ОНТҮГ-ын дарга
Т.Баяржаргал	-“Хэнтий-нийтлэг үйлчилгээ” ОНӨҮГ-ын дарга
Х.Ганчулуун	-“БЗӨБЦТС” ТӨХК-ийн Хэнтий цахилгаан түгээх сүлжээний дарга
Б.Сүнгээ	-Мэргэжлийн хяналтын газрын дарга
Д.Батхуяг	-Аймгийн “Зураач урчуудын холбоо”-ны тэргүүн, зураач /тохиролцсоноор/
Ч.Хос-Эрдэнэ	-Иргэний нийгмийн байгууллагын сүлжээний тэргүүн

2. “Чингис фестиваль - 2019” олон улсын наадмыг өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА